

Бизнесийн үйл ажиллагааг үр дүнтэй зөв удирдан зохион байгуулж, хөгжүүлэх 1С:ERP.

«Монгол Даатгал» ХХК-ийн туршлага

Хэдийгээр компани нь зах зээл дээр тэргүүлэх байр суурийг эзлэх болсон ч өөрийн үйл ажиллагааг зогсоож болохгүй. Өнөөдөр, өндөр технологи, инновацийн шийдлүүд хурдацтай хөгжиж буй энэ эрин үед хэн мэргэжлийн өндөр түвшинд өөрийн үйл ажиллагааг түргэн шуурхай явуулна, тэр л хожино. Өнөөдөр тэргүүлэгч байна гэдэг нь зах зээлийн өөрчлөлтийг хамгийн түрүүнд мэдэрч, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, түүнчлэн ашиг гэдэг зах зээлийн том шагналыг авахын тулд, өөрийн байр суурийг бэхжүүлэх шинэ дэвшилтэт арга, технологид бусдаас түрүүлж хөрөнгө оруулалт хийж өөрийн бизнесийн үйл ажиллагааг илүү оновчтой зохион байгуулах явдал юм. Үүний тулд компанийн дотоод үйл ажиллагаа болон зах зээлийн өөрчлөлтийг урьдчилан таамаглаж мэдрэх, түргэн шуурхай зохицох процессийг илүү хялбарчлах, мөн үйл ажиллагааны төлөвлөгөө болон бусад бизнесийн чухал зорилтуудыг шуурхай, цаг тухайд нь гүйцэтгэх боломжийг олгох бизнесийн зохистой хэрэгсэл хэрэгтэй. Эдгээр зорилтыг энэ онд өөрийн үйл ажиллагааны чухал процессуудыг автоматжуулах төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан Монголын хамгийн том даатгалын компани болох «Монгол Даатгал» тавьсан юм. Өнөөдөр тэднийг 1-д байж, үйл ажиллагаагаа өргөжүүлж хөгжүүлэх боломжийг дэлхий даяар 1 500 000 гаруй байгууллага, компанийн ашиглаж буй 1С програмын платформ дээр суурилсан автоматжуулсан 1С:ERP систем олгоно.

■ ЗАРЧМЫН ХУВЬД ХУУЧИН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙГ ХАЛЖ, ШИНЭ СИСТЕМД ШИЛЖИХ

Төслийн гол зорилго нь гар ажиллагааг бүрэн халж, бизнесийн бүх чухал чиглэлээр нэгдсэн мэдээллийг компанийн топ менежерүүдэд олгох боломжийг бүрдүүлсэн шинэ мэдээллийн ERP (с англ. Enterprise Resource Planning - Байгууллагын нөөц төлөвлөлтийн систем) системд, зарчмын хувьд, шилжихэд байсан юм. Шинэ системд шилжихэд шинэ системийн үндэс болсон санхүүгийн удирдлага, харилцагч болон бичиг баримтуудтай ажиллах зэрэг бизнесийн процессийг оновчтой болгох шаардлагатай байсан.

«Монгол Даатгал» компанийн ажилчид 2006 онд, санхүүгийн газрын тавьсан шаардлагад нийцүүлэн боловсруулж нэвтрүүлсэн бүртгэлийн системийг ашиглаж байсан. Систем дээр санхүүгийн стандарт тайлангуудыг бүрдүүлж, зохих даатгалын гэрээнүүдийг хэвлэж бүртгэнэ. Компанийн үйл ажиллагаа өргөжих, шинэ салбаруудыг нээж, хууль эрх зүй, гадаад орчны өөрчлөлт, мэдээллийн сан нэмэгдэх тусам хуучин систем шаардлага хангахгүй болж, цаашид даатгалын бүтэгдэхүүнд дүн шинжилгээ хийх, мөн өмнө нь автоматжуулаагүй байсан зарим нэг үйл ажиллагаануудаа автоматжуулах шаардлага гарсан. Компанийн үйл ажиллагаанд цаашид хуучин системийг ашиглах боломжгүй болсон юм. 2013 онд хуучин МТ шийдлийг өөрчилж шинэчлэх шийдвэр гарч, шинэ системд тавих тодорхой шаардлагуудыг боловсруулан гаргасан. Шинэ мэдээллийн систем нь «Монгол Даатгал» ХХК-ийн бүх салбаруудын мэдээллийг онлайн хэлбэрт оруулж нэгтгэх ёстой байсан.

Мөн газар нутгийн хувьд алслагдсан салбаруудын мэдээллийг тухай бүрд нь солилцож нэгтгэх явдал нь шинэ системд тавьсан хамгийн чухал шаардлагын нэг юм. Өмнө нь мэдээлэл татаж, солилцдог байсан хугацааны давтамж цөөн байлаа. Шинэ систем нь өөрийн бизнесийг цаашид өргөжүүлэх, өөрийн харилцагчдад зориулан санхүүгийн уян хатан шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, харилцагчийн дата өгөгдлийг ашиглан харилцагч бүрт тохирсон эрсдлийн хураамж тооцоолох боломжийг бүрдүүлэх нь чухал байсан.

Шинэ системийг нэвтрүүлэх түншээр нь 1С: ERP шийдлийн Монгол дах боловсруулагч «1С-Форус. Монгол» компани ажилласан.



Т. Батзул

Т.Батзул, «Монгол Даатгал» гүйцэтгэх захирал:

“ Манай хуучин системийн гол асуудал нь харилцагчийн зөв удирдлагыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүний загвар боловсруулахад дата өгөгдлийг боловсруулалт хангалтгүй, удирдлагын дэлгэрэнгүй тайлан гаргах боломж тааруу байсанд оршино. Бидний сонгосон «1C:Enterprise» дээр суурилсан шийдэл нь энэ асуудлыг шийдэх боломжтой болгож байгаа юм. Дэлхийн олон улс оронд 1 500 000 гаруй байгууллага энэ програмыг ашигладаг ба, одоо манай компани нь өөрийн бизнесийн гол үйл ажиллагаа, мэдээллийн урсгалыг дэлхийн стандартад нийцсэн удирдлагын системээр гүйцэтгэх боломжтой болсон нь том ололт мөн.



Евгений Тарасов, төслийн менежер:

“ Бидэнд, юун түрүүнд, өнөөгийн бизнесийн үйл ажиллагаа нь өмнөө тавьсан бизнесийн зорилтуудыг хэрхэн шийдвэрлэж буйг үнэлж, асуудалтай газруудыг илрүүлж тодорхойлох нь чухал байсан. Үүний дараа бид шинэ шийдлийн загварыг гаргаж боловсруулаад, туршилтын журмаар «Монгол Даатгал» компанийн хэд хэдэн салбар дээр суулгаж нэвтрүүлсэн. Ингэж бид шаардлагатай бүх нэмэлт, өөрчлөлт, боловсруулалтыг хийх боломжтой болсон юм. Зөвхөн үүний дараа л компанийн бүх салбар нэгжүүдэд нэвтрүүлсэн.



АМЖИЛТЫН ҮНДЭС –БАГ, СУРГАЛТ, ДЭМЖЛЭГ

Ямар ч МТ төслийн амжилт нь Захиалагч болон Гүйцэтгэгч талуудын мэргэжилтэн ажилчдаас бүрдсэн нэгдмэл нэгдсэн баг бүрдүүлэхээс шалтгаалдаг. «Монгол Даатгал» компанийн үйл ажиллагааг автоматжуулах энэхүү төсөлд даатгалын компанийн даатгалын газар, нөхөн төлбөр, бизнес хөгжил, санхүүгийн газрын гол гол мэргэжилтэн шинжээчид, «1C-Форус.Монгол» компанийн удирдлага, шинжээч, зөвлөхүүд нийлээд 25 болон түүнээс дээш тооны хүмүүс оролцсон. Үүний зэрэгцээ, хүний нөөц, худалдан авалт зэрэг, төсөл амжилттай хэрэгжих боломжгүй бусад үйл ажиллагааны чиглэл бүрээр тусгай ажлын хэсгүүд ажиллаж байсан. Төслийн энэхүү бүрэлдэхүүний тусламжтай олон асуудлыг түргэн шуурхай, төслийн багийн тувшинд шууд шийдэх боломжийг олгосон бат бөх харилцаа холбоог тогтоож чадсан юм.

Төслийг хэрэгжүүлэх явцад гардаг хүндрэлүүдийн нэг нь тухайн систем нь тавьсан шаардлагуудад нийцэхээс гадна янз бүрийн түвшний бэлтгэлтэй хэрэглэгчид ашиглахад хялбар байх естойд байдаг. Төслийн эхэнд даатгалын менежерүүд ажиллах хэсгийн интерфейс маш энгийн бөгөөд ойлгомжтой байх естой гэж шийдсэн. Үүний үр дүнд компанийн үндсэн үйл ажиллагаанд хохирол учруулалгүй, аажмаар хэрэглэгчид шинэ систем дээр ажиллаж сурсан. Үүнд шинэ програм дээр ажиллах чадварыг эзэмшүүлэх сургалт ч мөн нөлөөлсөн. Загвар програмыг нэвтрүүлэх шатанд цаашид бие даан бусад хэрэглэгчдийг сургах чадамж бүхий «Монгол Даатгал» компанийн ажилтан мэргэжилтэн нараас бүрдсэн ажлын хэсэг байгуулсан.

Хэрэглэгчдэд үзүүлэх тусламж зөвхөн анхан шатны сургалтаар хязгаарлагдах есгүй. Ажлын явцад янз бүрийн нөхцөл байдал үргэлж өөрчлөгдөж эсвэл шинээр үүсч байдаг. Одоо «Монгол Даатгал» дээр хэрэглэгчдэд тусалж, дэмжлэг үзүүлэх хоёр түвшинт систем буюу servicedesk ажиллаж байна. Эхний түвшинд хэрэглэгчийн асуулт эсвэл системийн алдааг даатгалын компанийн гол ажилтан зохицуулж шийднэ. Шинжээчийн оролцоо шаардлагатай тохиолдолд хоёрдугаар түвшин буюу «1C-Форус.Монгол» компанийн мэргэжилтэнд дамжуулан өгч шийдвэрлэнэ. Энэ бүгд нь тасралтгүй ажиллагаагаар хангаж, нэмэлт боловсруулалтыг цаг тухайд хийх боломжийг олгох дэмжлэг үзүүлэх үйлчилгээний гэрээний дагуу явагдаж байна.

1С нэвтрүүлснээр бизнесийн удирдлага болон өгөгдлийн сангийн автоматжуулсан нэгдсэн систем бий болсон бөгөөд «Монгол Даатгал» компанийн 30 салбарын мэдээллийг нэгтгэж, салбар бүрийн мэдээлэлтэй цаг тухайд нь танилцах боломжтой болсон. Дөрвөн сарын хугацаанд өнгөрсөн хугацааны хэдэн зуун мянган даатгалын гэрээ, гэрээт баталгаа, даатгалын зүйлийг шинэ системрүү хуулбарлан оруулсан. Мөн систем өмнө нь харилцагч, санхүү, даатгал, нөхөн төлбөр гэх мэт 7 дэд системээс бүрддэг байсан бол шинээр 11 дэд системийг нэмж оруулан, АЖД холбооны програмтай холбогдох тохиргоог хийсэн. Энэ нь байгууллагын бүх ажил, гүйлгээг бүртгэж, тэдгээрийн дараалсан “гинжин” харьцааг үүсгэх боломжийг олгосон. Тухайлбал, CRM дээр харилцагчийг бүртгэхээс эхлэн, хураамжийн төлбөртэй холбоотой санхүүгийн гүйлгээг бүртгэх, эрсдлийн үнэлгээг хийснээр давхар даатгалын явцыг ч энэ бизнес процесстой холбох боломжтой бөгөөд даатгалын тохиолдол үүсэх буруутай этгээдтэй холбоотой өргөдөл үйлдэхэд хуулийн хэлтэс шууд холбогдоно. Энэхүү «гинжин» урсгал нь газар нэгжүүд мэдээллийг давхардуулж оруулахаас сэргийлж, тэдний хоорондын харилцаа холбоог түргэн шуурхай зохицуулах боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд, харилцагчдад ч чанарын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэх боломжтой болж байгаа юм.

ГОЛ ҮР ДҮН БА ШИНЭ БОЛОМЖУУД

Шинэ мэдээллийн системийн архитектур нь удирдлагын түвшинд шийдвэр гаргахад хэрэгтэй мэдээлэлд, санхүүгийн үзүүлэлтэнд олон талын дүн шинжилгээ хийж төлөвлөх, бодит гарсан үзүүлэлтийг төлөвлөсөнтэй харьцуулж, гүйцэтгэлийн динамикийг харах, ямар үйл ажиллагаа явуулах эсэхийг тодорхойлох боломжийг олгосон. Үүний үр дүнд байгууллагын удирдлага гарсан өөрчлөлтөнд түргэн шуурхай хариу арга хэмжээ авч, шалтгааныг нь тодруулж зохих шийдвэрийг гаргах боломжтой болсон. Мөн тайлангаас нөхөн төлбөрийн мэдээллийг тодорхой хугацаа эсвэл тодорхой салбаруудаар харьцуулж, эсвэл ямар насны хүмүүс аль үйлчилгээнд илүү их хамрагдаж буй зэргийг харж болно.

Эдгээр аналитик мэдээллийг үндэслэн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлж, харилцагчдад илүү уян хатан үйлчлэх боломжтой болно. Мөн харилцагчийн хэрэгцээг дээд зэргээр хангахуйц даатгалын шинэ бүтээгдэхүүн гаргаж болно. Гол нь бүтээгдэхүүн хөгжлийн менежер програмистын оролцоогүй систем дээр өөрөө шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүнийг хязгааргүй тоогоор бие даан үүсгэж болно.

Т.Батзул, «Монгол Даатгал» компанийн гүйцэтгэх захирал:

“ Шинэ системийг нэвтрүүлээд удаагүй байгаа, гэхдээ бид тодорхой тогтсон бизнес процессийн дагуу нэгдсэн мэдээллийн сан дээр бодит цаг хугацаанд ажиллах, хэрэглэгчийн түвшинд ажлыг хөнгөвчлөх зэрэг эерэг үр дүн гарч байна. Компанийн санхүүгийн нэгдсэн тайланг богино хугацаанд үнэн зөв гаргаж байна, мөн бичиг баримтын удирдлага илүү боловсронгуй болсон.



Е.Тарасов

Евгений Тарасов, төслийн менежер:

“ Цогц ERP-системтэй болсноор «Монгол Даатгал» компани нь бизнесийн үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй удирдах, гадаад орчны хүчин зүйлсийн өөрчлөлт, нөлөөллийг цаг тухайд нь түргэн мэдэрч хариу арга хэмжээ авах, харилцагчдын үйлчилгээний чанарын сайжруулах зэрэг олон давуу талтай болсон. Эдгээр боломж нь компанийн удирдлага, ажилчдын өмнө нээлттэй тул тавьсан бизнесийн зорилгодоо хүрэхийн тулд идэвхитэй ашиглаж эхэлсэн. Төслийг хэрэгжүүлж дууссанаас хойш дор хаяж хоёр жилийн дараа компанийн үйл ажиллагааны үр ашиг, байгууллагын соелд гарсан эерэг нөлөө зэргээс төслийн үр дүн харагдаж эхлэнэ.